

НЭРТ БҮЖИГ ДЭГЛЭЭЧ Д.ЛАМЖАВЫН ЗАРИМ БҮТЭЭЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Жамъяндоржийн Эрдэнэхорлоо

Доктор (Ph.D), дэд профессор, Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургууль, Улаанбаатар, Монгол улс; БНХАУ-ын Хөлөнбуйр дээд сургууль, Хятад улс
bunt_dance@yahoo.com

Хураангуй: Монголын бүжгийн алтан санд орсон шилдэг бүжгийн бүтээлийг судлан шинжлэх нь бүжиг судлалын нэг чухал чиглэл юм. Тус өгүүллийн хүрээнд нэрт бүжиг дэглээч Д.Ламжавын “Морьт цэрэг”, “Цэнхэр дурдан алчуур”, “Уран хээ” хэмээх бүжгийн бүтээлд ажиглалт, дүн шинжлэл хийсэн болно.

“Морьт цэрэг” бол өвлийн цаснаар морио унаад дархан хилээ манаж яваа хилчин дайчдын дүрээр ХХ зууны монголын түүхэнд морьт цэргүүдийн гүйцэтгэсэн үүрэг, баатарлаг гавьяаг илэрхийлжээ. Бүжгийн хувцас, тайзны гэрэлтүүлэг, техникийн шийдэл нь тус бүжгийн дүр, орчныг бүрэлдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.

“Цэнхэр дурдан алчуур” нь цэрэгт мордож буй болон эр цэргийн албаа нэр төртэй хаагаад ирж буй залуус, ар амьдралаа авч яваа саальчин бүсгүйчүүдийн хоорондын харилцааг харуулсан бүтээл юм. Тус бүтээл нь хөдөө нутгийн ахуй амьдралын дэвсгэр дээр эрчүүдийн дүрийн өсөлтийг тод томруун илэрхийлснээрээ онцлогтой.

“Уран хээ” бол баяр наадмын гоёлоо өмссөн залуус уулзан учирч, тоглож наадаж, бие биедээ сэтгэлтэй болж, өрх гэр үүсгэж байгааг бүжгийн хэлээр харуулсан бүтээл болно. Тэрхүү өгүүлэмжийг нь монгол хээг бүжгийн зураглалаар бүтээсэн бэлгэдэлт дүрслэл улам тодруулж өгдөг.

Дээрх бүжгүүд нь залуу уран бүтээлчдэд жишиг болохуйц бүтээл бөгөөд бүжиг дэглээчийн арга барил, туршлага, эрдэм ухааныг танин мэдэхэд чухал эх хэрэглэгдэхүүн болж байна.

Тулхуур үг: сэдэв, дүр, зохиомж, санаа, хөгжим

OBSERVATIONS AND SURVEYS ON SOME CREATURES OF A FAMOUS CHOREOGRAPHER LAMJAV D.

Erdenekhorloo Jamiyandorj

Doctor (Ph.D), Associate Professor, School of Dance Art, Mongolian National University of Art and Culture, Ulaanbaatar, Mongolia; Hulunbuir University, Khulunbuir city, China

Abstracts: One vital field of choreography is to study top dance creatures reserved into golden fund of Mongolian dances. Within the framework of this research article, we have conducted some observations and analysis on famous choreographer Lamjav's creatures such as "Morit tsereg" (Cavalry), "Цэнхэр дурдан алчуур" (Blue silk scarf), "Uran khee" (Marvelous ornament) etc. The personal life and work experiences of this choreographer have become a foundation of creation of these art works. A composer Terbish has composed melodies for these three creatures as the wonderful combination of these talented choreographers and music composer has also become the outstanding results of their achievements. Mr. Lamjav used to make models of the dance costumes personally through personal choice of colors and materials for dresses and costumes and used the stage lightening and technique for creation of wonderful stage and dance environment. From his creatures you can see that he could have joined all the tools and methods into a wonderful combination for the expression of dance works.

Cavalry and Blue Silk Scarf were a military work expressing the warriors of Khalkh Gol World War period and reflecting the mentality of military officers and warriors of that period through perfect combination of Mongolian national dance movements and tactics with army dance features and typology so that it has become a renovation and update in the Mongolian army dance. Marvelous ornament is a unique creature that expresses various Mongolian ornaments through dance imaginations as a main tool of ornamental expression. Moreover, it has also expressed the love relations of young people in comparison with ornamental figures and composed in perfect combinations as a feature of the creature.

Research works on choreographer Lamjav will be vital for its opportunities granted to younger performers, dancers, and choreographers to learn experiments of olden experienced choreographers and to clarify dance creature composition of the 20th century Mongolian traditional dance art.

Keywords: theme, character, composition, idea, dance music

Оршил

XX зууны бүжгийн урлагийн нэрт төлөөлөгчдийн нэг нь Монгол улсын Гавьяат жүжигчин Д.Ламжав юм. Тэрбээр 300 шахам бүжиг, "Бөртэ чоно" бүжгэн жүжиг дэглэн найруулсан бүжиг дэглээч хүн. Түүний намтар, уран бүтээлийн талаар бүжиг судлаач, багш Г.Долгорсүрэн (2007), Д.Нанжид (2009) нар тоймлон бичихдээ уран бүтээлчийн онцлог талыг нь тодруулж, өөр өөрсдийн үнэлэлтийг өгчээ. Тухайлбал, Ардын багш Г.Долгорсүрэн "Манай урлагийн алтан үеийн иртэй,

эртэй, гарамгай төлөөлөгчийн нэгэн том оргил нь Д.Ламжав юм” (Долгорсүрэн, 2007, 43) хэмээн үнэлжээ. Мөн “Цэргийн чуулгынхан” (2012), “Соёл, урлагийн тайлбар толь: Бүжиг” (2018) бүтээлд түүний товч намтрыг оруулсан байна.

Тус өгүүллийн хүрээнд “Морьт цэрэг” (1983), “Цэнхэр дурдан алчуур” (1984), “Уран хээ” (1986) хэмээх дөч шахам жил тайзнаа тоглосоор буй Д.Ламжавын шилдэг бүтээлийг нь судалж, уран сайхны үнэ цэн, онцлогийг нь тодруулахыг зорьсон юм. Бүжгийн зохиомж буюу бүжгийн хөдөлгөөн, зураглалаар илэрч буй утга санаа, дүрийг хөгжимтэй нь уялдуулан тайлан тайлбарлаж, бүжиг дэглээчийн ур ухааныг нээн харуулахыг эрмэлзсэн нь уг өгүүллийн шинэлэг тал юм.

Судалгааны арга зүй

Бүжгийн бүтээлийг судлах онол, арга зүйн дагуу Д.Ламжавын шилдэг бүтээлүүдийг ажиглаж, задлан шинжлэхдээ сэдэв, санаа, дүр болоод хөгжим, бүжгийн зохиомж (хөдөлгөөн, зураглал), хувцас, гэрэлтүүлэг, жижиг хэрэглэл гээд бүжгийн бүтээлийг бүрдүүлж буй бүхий л хэсгийг авч үзэж үнэлэлт дүгнэлт өгсөн болно.

Бүжиг дэглээч Д.Ламжав (91 настай), хөгжмийн зохиолч Г.Тэрбиш (73 настай) нартай ярилцлага хийж, түүнээсээ эш татаж оруулсан нь уг өгүүллийн үнэ цэнийг өргөж байна.

Судалгааны үр дүн

Бүжиг дэглээч Д.Ламжавын урын санд цэрэг, эх орны сэдэвтэй бүжиг томхон байр эзэлдэг. ЦДБЭЧ-ын тайзнаа “Морьт цэрэг”, “Цэнхэр дурдан алчуур”, “Баярын өдөр” бүжиг нь амьдарсаар байгаа бол “Цагдаа залуус” бүжиг нь цагдаагийн Сүлд чуулгын нүүр царай болж байна. Тэрбээр “Морьт цэрэг”, “Цэнхэр дурдан алчуур” бүжгээрээ түүхэн сэдэв рүү хандаж, 1939 оны Халх голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайны үеийн цэрэг дайчдын дүрийг бүтээсэн юм. “Морьт цэрэг” бүжгээрээ эх орноо харийн түрэмгийлэгчдээс хамгаалахад онцгой гавьяа байгуулсан Ш.Гонгор, Л.Дандар баатар тэргүүтэй XX зууны монголын морьт цэрэг, хилчин дайчдын яруу алдрыг магтан дуулсан бол “Цэнхэр дурдан алчуур” нь 1940-өөд оны үед эх орноо хамгаалахаар цэрэгт мордож буй эрчүүд, тэдний ар талын амьдралыг авч үлдсэн эмэгтэйчүүд, тэдний хоорондын харилцааг харуулсан бүжиг юм.

Морьт цэрэг: Д.Ламжав МААДБА-д бүжгийн багшаар ирээд, ямар сэдвээр цэргийн бүжиг дэглэх билээ гэж бодоход нь 1945 оны үед Ш.Гонгор баатрын тухай дуугүй кино үзсэн нь санаанд нь оржээ. “Тэр кинонд Ш.Гонгор баатар цасан дунд байлдаж байсан. Жинхэнэ цэрэг гэж ийм л хүн байдаг юм байна гэж хүүхэд байхад тархинд буусан нь санагдаад” (Ламжав, 2022) хэмээн “Морьт цэрэг” бүжгийнхээ үүдэл санааг олсон тухайгаа хуучилсан юм. Бүжиг дэглэж эхлэхээсээ өмнө хөгжмийн зохиолч Г.Тэрбиштэй хамт Кино үйлдвэр дээр очиж мөнөөх киногоо дахин нэг үзсэн гэнэ.

Морьт цэрэг бүжгийн гаралт онцгой; Үүр цайж, цас бударч байхад 12 морьт цэрэг хоёр эгнээ болон тайзны зүүн талаас гарч ирэх бөгөөд харц нь явах чигийг заана. Баруун гараар ташаа тулж, цээжийг баруун тал руугаа эргүүлж, зүүн гарыг жолоо барьж байгаагаар урагш сунгаж барина. Тийм маягаар толгой, цээж, гарыг хөдөлгөхгүйгээр барьж явах бөгөөд хөлийг нугалж өргөнгөө өлмийгөөр товшин

урагшлах хөдөлгөөн нь хөр цасан дунд явж буй морины явдлыг илтгэнэ. Уг гаралт нь үзэгчийн зүгээс бүжигчний биеийн байрлал, хөдөлгөөний харагдах байдлыг нарийн тооцоолсон бүжиг дэглээчийн ажиглах чадвар, ур ухааныг илтгэнэ.

Морьт цэргийн дүрийг илэрхийлэхдээ, бүжигчдийн гарын барилтаар морь жолоодож байгааг хөлийн олон хэлбэрийн баялаг хөдөлгөөнөөр морины явдал гишгэдлийг илэрхийлжээ. Саравчлан харж байгаа, газар хэвтэж чимээ чагнаж байгаа хөдөлгөөнүүд нь дайсны халдлага дайралтаас сэргийлж, хил хязгаараа хамгаалж байгаа байдлыг харуулжээ. Гараа атгаж, нударга зангидаж байгаа холбоос хөдөлгөөнүүд нь дайсан халдан довтолбол тулалдахад бэлэн гэдгээ эрс шийдэмгийгээр илэрхийлж буй санаа мөн.

Бүжгийн оргил хэсэгт нэг гар дээр тулж арагш гойройтон тойргоор эргэх, өлмийцөж далаар хэвтэх, нумлаа, матар, жете антурнан (jeté en tournant) зэрэг цэрэг эрсийн дайчин төрх, эрэмгий зоригийг илтгэсэн трюк хийнэ. Бүжигчнээс ихээхэн хүч чадал, хурд, авхаалж самбаа, арга техник шаардсан бүжгийн трюк 1960-аад оноос цэргийн бүжигт нэвтэрч эхэлжээ. Ингэхдээ трюкийг гол төлөв бүжгийн зохиомжийн тусдаа нэг хэсэг болгож оруулдаг байв. Тухайлбал, 1974 онд дэглэснээс хойш өнөөг хүртэл тоглосоор байгаа Ш.Гун-Аажавын хөгжмөөр Б.Банзрагчийн дэглэсэн “Цэрэг бүжгийн чуулбар” бүжгийн дунд хэсэгт трюкийн хэсэг орсон байдаг. Энэ хэсэгт гол төлөв эрэгтэй бүжигчид эр чадлаа харуулсан олон хэлбэрийн трюкийг ээлж ээлжээр хийх үед бусад бүжигчид хагас тойрог болж зогсоод, тэднийг дэмжиж байгаагаа илэрхийлэн алга ташдаг. Харин “Морьт цэрэг” бүжигт трюкийг ингэж тусгаар хэсэг болгохгүйгээр бүжгийн өгүүлэмж, зураглалтайгаа нягт уялдуулан зохиомжилсноороо онцлогтой. Тухайлбал, бүжигчид тайзны голд буу барьж, отоож байгаа маягтай бөөгнөрөн суухад, нэг бүжигчин тэднийг тойрч жете антурнан хийнэ.

XX зуунд монголын морьт цэргүүд сэлэм барьж дайтаж байсан түүхтэй аж. Түүнтэй холбоотойгоор сэлэм далайсан дайчин эрс давхиж гарч ирээд, улаан тугийн дор нэгдэж байгаагаар бүжиг өндөрлөнө. Улаан туг барьсан хүн голд нь зогсоход, бусад нь гурвалжин байрлалаар хүрээлэн суудаг. Төгсгөлийн энэ байрлал нь хилчин дайчид бид тусгаар улсынхаа дархан хилийг сумны зэв мэт баттай хамгаална гэсэн гүн утгыг илэрхийлнэ (Зураг 1).



Зураг 1. “Морьт цэрэг” бүжгийн төгсгөлийн төхөл. ЦДБЭЧ-ын архиваас. 2005 он.

Хөгжмийн зохиолч Г.Тэрбиш “Морьт цэрэг бүжгийг дэглэж байх явцад нь бүжгийн хөдөлгөөнийг харж байгаад хөгжмөө зохиосон. Балетмейстрын сэтгэлгээг, бүжигчдийн сэтгэл зүйг хөгжмөөр илэрхийлэхийг зорьсон” (Тэрбиш, 2021) хэмээн өгүүлж байна. Энэ нь бүжгийн хөдөлгөөний аяс намба, айзам хэмнэлээс хөгжмийнхөө аялгуу, хэмнэлийг тусгаж авсан гэсэн үг юм. Хөгжмийн зохиолч, цэргүүд амарч байгааг харуулсан бүжгийн хэсэгт “Ширээ нуур” хэмээх бэсрэг уртын дууны аялгуут оруулжээ. Цэргүүд байгалийн сайханд амар тайван байдлыг мэдэрч байгаа дүр зургийг илэрхийлэхэд уртын дууны сэтгэл тэнийм аялгуу суурь болж өгдөг. Нэрт хөгжмийн зохиолч Л.Мөрдоржийн “Хилч би” хэмээх дууг бүжгийнхээ гутгаар хэсэгт ашигласан нь хилчин дайчдын дүрийг тодруулахад тус нэмэр болсон.

Монгол цэргийн бүжгийн урын санд байдаг өвлийн хувцастай буюу цагаан нэхий дээлтэй цор ганц бүжиг бол “Морьт цэрэг” юм. Бүжиг дэглээч өөрөө хувцасны загвараа гаргасан бөгөөд санаанд нь таарсан хувцасны материал олдохгүй байжээ. Харин тайзны кулис¹ тохирмоор санагдаад, аж ахуй хариуцсан ар талын орлогч Х.Бадраад хэлсэнд дэмжсэн гэнэ. Ингээд тайзны кулисийг буулгаж, агуулахад байсан үлдсэн материалыг нэмээд, “Морьт цэрэг” бүжгийн хувцсыг хийсэн аж. Дээлээ хурганы арьсаар эмжсэн нь бүр зохимжтой болжээ.

Тус бүжгийн бас нэг онцлог нь гэрэлтүүлэг, тайзны эффектийг бүжгийн орчинг бүрдүүлэхэд оновчтой ашигласанд байна. Бүжиг эхлэхэд, тайзны гэрэлтүүлгээр үүр цайж буйг, проектороор цас намуухан бударч байгааг харуулдаг. Энэ нь үүрийн гэгээнээр дархан хилээ хамгаалахаар явж буй морьт цэргүүдийн дүрийг тодотгож, үзэгчдэд яг л кино үзэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг.



Зураг 2. “Цэнхэр дурдан алчуур” бүжиг. ЦДБЭЧ-ын архиваас. 2000 он.

¹ Тайзны хажуугийн хөшиг

Цэнхэр дурдан алчуур: “Цэнхэр дурдан алчуур” хэмээн алдаршсан “Амрагийн дуу”-г 1943 онд зохиожээ. Уг дуунаас сэдэвлэн 1984 онд Д.Ламжав “Цэнхэр дурдан алчуур” бүжиг дэглэж, Г.Тэрбиш хөгжмийг нь бичжээ. “Цэнхэр дурдан алчуур бол ард түмний сайн мэддэг, зүрх сэтгэлд нь хоногшсон дуу. Ийм сайхан дуу байхад цэргийн бүжиг дэглэж байгаа хүн энүүгээр бүжиг дэглэхгүй байж болохгүй. Хүний чихэнд нь сонсогддог төдийгүй нүдэнд нь харагддаг юм хийе гэж бодсон” (Ламжав, 2012) хэмээн Д.Ламжав уг бүжгийнхээ үүдэл санааны талаар ярьсан болно.

Цэрэгт явсан амрагаа санан мөрөөдсөн бүсгүй хүний сэтгэлийг илэрхийлсэн “Амрагийн дуу”-тай нэгэн адил “Цэнхэр дурдан алчуур” нь утга уянгын аястай бүжиг юм. 1940-өөд оны үед цэргийн албыг 3-5 жил хаадаг, тэр хугацаанд бичиг үсэг сургаж, боловсрол, мэргэжил эзэмшүүлдэг тогтолцоотой байжээ. Тэрхүү монгол эр хүнийг хүмүүжүүлж, төлөвшүүлж ирсэн цэргийн албаны түүхэн үүргийг “Цэнхэр дурдан алчуур” бүжигтээ тусгасан юм. Тус бүжигт хөдөө нутгийн ахуй амьдралын дэвсгэр дээр эр цэргийн албанд мордож буй эрчүүд, эх оронч үүргээ нэр төртэйгөөр биелүүлэхэд ирж буй залуус, амраг хайртай хүнээ санан мөрөөдөж буй саальчин бүсгүйчүүдийн дүрийг гаргажээ. Ялангуяа цэрэгт мордохоос өмнөх болон цэргээс халагдаж ирсний дараах малчин залуусын дүр, тэдний дүрийн өсөлт, өөрчлөлтийг бүтээж чадсанаараа давуутай. Тодруулбал, цэрэгт явах гэж хөөрч, онгирч байсан залуус, цэргийн алба хаагаад ирэхдээ өрх гэр, аж амьдралаа аваад явах чадвартай, жинхэнэ төлөвшсөн эр хүн болдгийг уг бүжгээр харуулдаг.

Уг бүжиг нь эхлэл, эрчүүдийн ташууртай бүжиг, эрэгтэй эмэгтэйчүүдийн хамтын бүжиг, дан эмэгтэйчүүдийн бүжиг, төгсгөлийн хамтын бүжиг гээд нийт таван хэсгээс бүрдсэн арван минут шахам үргэлжлэх томоохон чуулбар бүжиг юм. Нэгэн бүсгүй өглөө босоод үс гээгээ тольдож янзлаад, өрхөө татаж байтал хоёр найз нь ирж, өврөөс нь цухуйж байсан цэнхэр дурдан алчуурыг нь сэмхэн авч, хэнд зориулж оёсныг нь асууж, тоглож байгаагаар бүжиг эхэлдэг. Улмаар нутгийн хоёр залуу давхисаар гарч ирээд, бүсгүйчүүдийг дайрах шахаж байгаагаар бүжиг өрнөнө. Тэдний араас бусад залуус гарч ирж, ташууртай бүжиг бүжиглэдэг нь эр цэргийн албанд мордох болсондоо баярласан сэтгэлийн баяр хөөрийг нь илтгэнэ. “Намайг хүүхэд байхад манай голын ах нар цэрэгт мордохынхоо өмнө бөөн бөөнөөрөө айл хэсээд, хэд хоног л бөөн хөл хөдөлгөөн болдог байсан юм. Тэгээд цэрэгт яваад өгчихөөр эл хул болчихдог. Тэр тухай бодож хийсэн юм” (Ламжав, 2022) хэмээн бүжиг дэглэж өгүүлсэн билээ. Үнэхээр ч тухайн үед цэргийн албанд тэнцэнэ гэдэг бол эрийн цээнд хүрч, эр хүн болсны баталгаа, бахархал болдог байжээ. Бүсгүйчүүдээ ташуураа үлдээгээд явахдаа таахалзан алхсаар ордог нь цэрэгт мордох гэж яарсан сэтгэлийг нь илтгэдэг. Бүжгийнхээ элемент болгонд дүрийнхээ зан төрхийг шингээж өгдөг бүжиг дэглээчийн ур ухаан эндээс харагдаж байна.

“Цэнхэр дурдан алчуур” бол цэргийн бүжгийг монгол ахуй орчинд нь аваачсан бүжиг юм. Эмэгтэйчүүд ноос савж, сүү сааж, цацал өргөж, эрчүүд нь өвс хадаж байгаа үйлдлийг бүжгийн хөдөлгөөнөөр илэрхийлдэг (Зураг 2). Эрчүүд нэг нэгнийхээ ташуурын үзүүрийг барьж, дээш өргөн тойрог болж зогсоод монгол гэр, ташуураа зөрүүлэн барьж зогсоод ханын дүрслэлийг бий болгоно. Гурван бүсгүй тойргийн голд тулгын гурван чулуу болж зогсоод, гарын хөдөлгөөнөөр галыг дүрсэлдэг нь хамтдаа гал

голомтоо бадраая гэсэн бэлгэдэлт утга аж.

Тус бүжгийн жижиг хэрэгтэл болох “алчуур”, “ташуур”, “хувин” нь дүрийг тодотгож, бүжгийн утга санааг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Хайртай залуугаа цэрэгт мордоход “Цэнхэр дурдан алчуур” бэлтгэдэг нь сэтгэлийн нандин харилцааных нь илрэл болдог бол алчуураа ташууранд зангидаж өгдөг нь бүсгүйн цэвэр ичимхий зан чанарыг илтгэнэ. Эрчүүд нь бүсгүйчүүддээ “ташуураа үлдээж байгаа нь морио үлдээж байна л гэсэн үг шүү дээ” (Ламжав, 2022) гэж бүжиг дэглээч ярьсан юм. Энэ нь морио буюу ар гэр, аж амьдралаа даатгаж үлдээж байгаа гүн санаа болно.

Бүсгүйчүүдийн саалийн бүжгийн хэсэгт хоорондоо шивнэлдэж, хөөрөлдөж байгаад, дээлийнхээ хормойг алгадаж, хувингийнхаа зүг явах нь “Үг олдож, үхэр холдлоо”, сааль сүү оройтлоо гэсэн утга юм. Залуус бие биеэ санан мөрөөдөж, бие биерүүтгээ тэмүүлж, учран золгож байгаа хөдөлгөөнүүдээрээ “Зүрхний амраг чи минь, Зүүднээс ердөө ч салдаггүй” гэсэн дууны өгүүлэмжийг илэрхийлсэн байна. Тэрхүү өөд өөдөөсөө тэмүүлэн явж байгаа хөдөлгөөнийг удаашруулсан байдлаар үзүүлсэн нь туйлын оновчтой, өвөрмөц шийдэл болжээ. Бүжгийн төгсгөлд залуус нь хувинтай сүүг нь барьж, бүсгүйчүүдийнхээ хамт ороход, цэнхэр дурдан алчуурны эзэн бүсгүй алчуураа бариад намируулаад явдаг нь энх цагийн амар тайван, аз жаргалтай амьдралыг илтгэнэ. “Цэнхэр дурдан алчуур” бүжгээс үзэгчид 1940-өөд оны үеийн хөдөө нутгийн залуусын амьдралыг тольдож, тухайн үеийн орон зай, цаг хугацаагаар аялсан мэт мэдрэмж авдаг билээ.

Уг бүжгийн эрчүүдийн хэсгийн хөгжмийг захиалахдаа бүжиг дэглээч “Цэрэгт мордох гээд хэд хоног айл хэсэж, аяга тагш юм балгасан халамцуу залуус гарч ирэх юм шүү” (Тэрбиш, 2021) гэж хэлж байжээ. Тиймээс залуучууд давхиж гарч ирээд, ташуур барьж бүжиглэдэг хэсгийн хөгжмийг бичихдээ үндсэн аялгуун дээр цаанаа цуурайтай, хөөцөлгөөтэй (канон) байдлаар зохиомжилсон байна. Залуусын бүсгүйчүүдтэйгээ хамтран бүжиглэдэг хэсгийн хөгжмийг бичихдээ “эр хүний халуун хайрыг” илэрхийлэхийг зорьсон хэмээн хөгжмийн зохиолч өгүүлсэн юм. Мөн 1939 онд Л.Мөрдоржийн хөгжмийг нь зохиосон “Байлдаанч суман” хэмээх дууны аялгууг оруулж, цэрэгт мордох болсон залуусын дүрийг тодруулж өгчээ.



Зураг 3. “Уран хээ” бүжгийн төгсгөлийн төхөл. ЦДБЭЧ-ын архиваас. 2020 он.

Тус хэсгийн аялгуу дээр цэргийн дуудлага оруулсан нь цэрэгт мордох цаг болсныг сануулна. Хөгжмийн зохиолч “Би бүжгийн хөгжмийг контрапунктын аргаар зохиохыг бодож байлаа. Тэр ч ёсоороо бүжгийн өгүүлэмжийг илэрхийлэхийн тулд үндсэн аялгуун дээр туслах аялгуу, холбоос, чимэглэл оруулж бүжгийн зөрчил тэмцэл, сэтгэлийн өнгө аясыг тодруулсан” (Тэрбиш, 2021) гэж өгүүлсэн юм. Бүжгийн хөгжмийн зохиомжийн энэ арга нь бүжгийн хөгжмийг баялаг дуурьсалтай, өгүүлэмжтэй болгож, бүжгийн дүрийг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Уран хээ: Д.Ламжав УАДБЧ-д бүжигчин байхдаа 1966 онд “Идэрчүүд” хэмээх бүжиг дэглэж уран бүтээл туурвих гараагаа эхэлснээс хойш монгол бүжгийн хэв маягаар “Эмнэг сургагч”, “Монгол аялгуу”, “Хүрээ намба”, “Өвөөгийн гутал”, “Үүлэн бор”, “Наран тогоруу” зэрэг олон арван бүжиг дэглэн тавьжээ. Эдгээрээс орчин цагийн монгол бүжгийн шилдэг бүтээлийн тоонд зүй ёсоор орох онцгой бүтээл бол “Уран хээ” мөн. 1978 онд Игорь Моисеевийн нэрэмжит Ардын бүжгийн улсын эрдмийн чуулгын “Вензеля” гэдэг орос ардын бүжгийг Зөвлөлтийн мэргэжилтэн багш В.Багшеев УАДБЧ-ын бүжигчдэд зааж өгч тоглуулжээ. “Вензеля бол тоглож байгаа хүмүүстэй мэдрэмжтэй, аятайхан бүжиг байсан юм. Үүн шиг монгол бүжиг хийх юм сан” (Ламжав, 2022) гэж тэр үед Д.Ламжав гуай боддог байжээ. Хожим нь МААДБЧ-д бүжиг дэглээчээр ажиллаж байхдаа нэг өдөр шагай харваж байгаад дүүжин оноод бөөн баяр болжээ. Тэгсэн чинь гэнэтхэн нөгөө Вензеля шиг монгол бүжиг хиймээр санагдаад явчихсан хэмээн тэрбээр хуучилсан юм. Дүүжин буюу хожлын хасааг оносон урам нь түүний далд ухамсарт байсан үүдэл санааг сэрээснээр “Уран хээ” бүжиг дэглэх болсон аж.

Уг бүжиг нь олон хэлбэрийн монгол хээг бүжгийн хайрцаг зураглалаар дүрсэлсэн дахин давтагдашгүй бүтээл билээ. Тиймээс МААДБА-д утга зохиолын эрхлэгчээр ажиллаж байсан Ардын уран зохиолч П.Бадарч “Уран хээ” хэмээх нэр хайрлажээ. Тухайлбал, Бүжгийн эхэнд эрэгтэйчүүд тайзны баруун талаас, эмэгтэйчүүд зүүн талаас гардаг бол бүжгийн төгсгөлд “хаан бугуйвч” хээг бүжгийн зураглалаар дүрсэлдэг нь хослон жаргахыг бэлгэдсэн утга болно (*Зураг 3*). Энэ нь бүжгийн зураглалаар утга илэрхийлж буй уран шийдэл мөн. Үүний учир Ардын жүжигчин Д.Нанжид “Ламжав, аливааг ургуулан бодох уран сэтгэмжтэй, хувьсгаж чаддаг ухаантай хүн” (Нанжид, 2009, 90) хэмээн дүгнэжээ.

“Уран хээ” бүжигт баяр наадмын гоёлоо өмссөн залуучууд уулзаж танилцаад, ойртон дотносож, улмаар гэр бүл болж байгаа тухай өгүүлдэг. Ингэхдээ хос залуусын сэтгэлийн нандин харилцааг уран хээтэй зүйрлэж, сүлэлдүүлэн зохиомжилсноороо онцлог. Иймээс уг бүжигт хослон бүжиглэх олон хэлбэрийн гарын барилт орсон байна. Хөтлөлцөн алхах, эрэгтэй нь мөрөөр нь тэврэх зэрэг амьдралаас тусгаж авсан барилтаас гадна нурууныхаа ардуур гараа атгалцан барих, золгож буй мэт барих зэрэг монгол маягийн барилтуудыг бүжиг дэглэлтдээ оруулжээ. Эмэгтэйчүүд хоёр хоёроороо сугадалцаад, гараа урдаа дугуйруулан барьж, “хатан сүйх”-ийг дүрсэлдэг. Хосоор бүжиглэх арга маягийг ийм баялаг байдлаар шийдсэн монгол бүжиг “Уран хээ”-ээс өөр ховор болов уу.

Мөн эрэгтэй нь чихэнд нь юм шивнэх, эмэгтэй нь чагнах, эмэгтэй нь мөрөөр нь тэвэрсэн гарыг нь ичингүйрэн түлхэх, “Цагаан тэмээцэж” тоглох зэргээр залуус

өөр хоорондоо тоглож наадаж байгааг харуулдаг нь бүжгийг улам сонирхолтой болгодог. Залуус тойрон эргэлдэн бүжсээр хагас тойрог болж, бүжгийн зураглалаар гэрийг дүрслэхэд, тэдний дунд цомцойн суусан хос хоёрын эмэгтэй нь эрэгтэйнхээ хантаазны товчийг хадаж, сүүлчийн учгаа зангилж дуусна. Хань нөхөртөө хайраа шингээж оёж өгсөн дээл хувцсаа засаж янзалж, “Эд нь хэврэг, эзэн нь мөнх байх болтугай” гэж ерөөж байгааг бүжгийн үйлдлээр илэрхийлнэ. “Уран хээ” бүжгийн амин сүнс нь хос залуусын харилцааг монгол сэтгэлгээгээр илэрхийлж чадсанд оршиж буй.

Д.Ламжав багш “Тэрбиш маягтай гоё хөгжим бичсэн. Сайхан хөгжим болохоор намайг хөглөөд л аваад явчихсан. Хөдөлгөөн өөрөө л орж ирээд байсан” (Ламжав, 2022) хэмээн дурсав. Хөгжмийн зохиолч бүжгийн удаан хэсгийн хөгжмийг бичихдээ “мяндсан утас хөвөрч байгаа юм шиг” (Тэрбиш, 2021) гэж хэлсэн бүжиг дэглээчийн санааг тусгажээ. Тиймээс үндсэн аялгууны ард арф хөгжмөөр арфеджио тоглуулсан нь нээрээ ч утас хөвөрч байх шиг сонсогддог. Мөн удаан хэсгийн дунд “Сандуйтай мод” ардын дууны аялгууг оруулсан нь бүжгийн намба төрхийг тодруулж өгдөг.

Хөгжмийн зохиолч Г.Тэрбиш “Туч, дөчөөд оны үеийн залуучууд бүсгүйчүүдтэй танилцахдаа – Алдар нэр чинь хэн юм бэ? Аль хороонд суудаг вэ? ... гэх зэргээр дуулдаг Анкетын дуу байсан гэж Цэрэндулам² гуай надад аялж өгч байв. Тэр Анкетын дууны аяыг би Уран хээгийн хурдан хэсэгт оруулсан” (Тэрбиш, 2021) хэмээн ярьсан юм. Бүжгийн хурдан хэсгийн хөгжим нь тоглож наадаж байгаа залуусын харилцааг харуулахад яв цав тохирсон байна. Үүний дээр МААДБА нь монгол ардын хөгжмийн зэмсгийг европ хөгжмийн зэмсэгтэй нэгтгэсэн, холимог найрал хөгжимтэй байсан нь үндэсний хөгжмийн хөг аялгуу, хэв шинжийг илэрхийлэхэд чухал нөлөөтэй байсныг уран бүтээлчид онцолж байна.

Хэлэлцүүлэг

Цаг хугацааны шалгуурыг давж, монголын бүжгийн алтан санд орж, зуун дамжин амьдарсаар буй шилдэг бүжгийн бүтээлийг судлан шинжлэх нь бүжиг судлалын нэг чухал чиглэл юм.

Аливаа бүжгийн бүтээлийг судлахдаа уран бүтээлчидтэй нь уулзаж ярилцах нь уран бүтээлийн жаргал, зовлонг нь ойлгох, уран бүтээлчийн дотоод ертөнц, бодол санаа, авьяас чадвар, хөдөлмөр зүтгэлийг нь таньж мэдэх хамгийн чухал арга болох нь тодорхой. Иймээс уран бүтээлчидтэй ярилцлага хийж, баримтжуулж авч үлдэх нь урлаг судлалд үнэт эх хэрэглэгдэхүүн болох юм.

Ардын урлагийн биет бус өв нь өвлөн уламжлагчтайгаа устах аюултай гэдгийг бид сайн мэддэг болоод байна. Үүний нэгэн адил орчин цагийн мэргэжлийн урлагийн үнэт өвийг бидэнд уламжлуулсан ахмад уран бүтээлчид, тэдний бүтээл туурвилын үнэ цэнийг ухаарч, судлан шинжлэх ажлыг эрчимжүүлэх нь тулгамдаж буй асуудал болж буйг та бүхэнд сануулах юун.

² Гавьяат жүжигчин. Монголын Ардын армийн дуу бүжгийн чуулгын ахмад жүжигчин Ё.Цэрэндулам

Дүгнэлт

Нэрт бүжиг дэглээч Д.Ламжавын шилдэг бүтээлүүдийг шинжлэн судалсны үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

- Бүжиг дэглээчийн туулсан амьдрал, уран бүтээлийн туршлага нь бүжгийн бүтээлийнх нь суурь болжээ. Тэрбээр ахуй амьдралын үйлдэл, хөдөлгөөнөөс ургуулан сэтгэж, бүжгийнхээ хөдөлгөөнийг дэглэдэг, туйлын ажигч гярхай, уран сэтгэмжтэй бүжиг дэглээч болох нь харагдаж байна.
- Бүжгийн бүтээлийнх нь амжилт хөгжимтэй салшгүй холбоотой. Энэ нь хөгжмийн зохиолчтойгоо нягт хамтран ажиллаж, бие биеийнхээ уран бүтээл туурвих арга барилыг таньж мэдсэний үр дүн ажээ.
- Д.Ламжав бүжгийн хувцасныхаа загварыг өөрөө гаргаж, өнгө будгийг нь шийдэж, тайзны гэрэлтүүлэг, техникийг бүжгийн орчинг бүрдүүлэхэд чиглүүлж, цогц бүтээл туурвижээ. Мөн туг, сэлэм болон ташуур, хувин, алчуур гэсэн жижиг хэрэглэлийг ашиглаж, бүжгийн дүр, санааг тодруулж өгчээ.
- Түүхэн сэдвээр туурвисан “Морьт цэрэг”, “Цэнхэр дурдан алчуур” бүжиг нь монгол цэрэг, армийн түүхэн баатарлаг гавьяа, цэргийн албаны нийгэмд гүйцэтгэсэн үүргийг тод томруун харуулжээ. Цэргийн бүжгийн илэрхийллийн нэг хэрэгсэл болох трюкийг бүжгийн өгүүлэмж, зохиомжтой нэгтгэж дэвшил хийсэн нь ажиглагдаж байна.
- “Уран хээ” бол олон хэлбэрийн монгол хээг бүжгийн зохиомж, хайрцаг зураглалаар дүрсэлсэн төдийгүй хос залуусын сэтгэлийн харилцааг уран хээтэй зүйрлэж, сүлэлдүүлэн зохиомжилсон, монгол бүжгийн алтан санд орсон “нандин бүжиг” мөн болой.

Бүжиг дэглээч Д.Ламжавын уран бүтээлийг судлах нь ХХ зууны монголын бүжгийн бүтээлийн туурвил зүйг тодруулах, залуу уран бүтээлчдэд бүжиг дэглээчийн арга туршлагаас суралцах боломж олгож байгаагаараа ач холбогдолтой.

Талархал

Уран бүтээлийнхээ тухай ярьж өгсөн бүжиг дэглээч, Гавьяат жүжигчин Д.Ламжав, хөгжмийн зохиолч, Гавьяат жүжигчин Г.Тэрбиш, Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын Бүжгийн албаны уран бүтээлийн видео бичлэг (DVD), бүжгийн бүтээлүүдийн зураг өгсөн ЦДБЭЧ-ын дэд дарга, уран сайхны удирдагч, бүжиг дэглээч, хошууч Л.Баттөр, бүжгийн бүтээлүүдийн талаар санал бодлоо хуваалцсан бүжиг дэглээч, Гавьяат жүжигчин Л.Ганчимэг, бүжиг дэглээч Л.Баттөр нарт гүн талархал илэрхийлье.

Ашигласан материалын жагсаалт

Ном

1. Долгорсүрэн, Гарам. 2007. *Бүжгийн урлаг*. Улаанбаатар, Монгол Улс: Соёлын дээд сургуулийн хэвлэх үйлдвэр.
2. Нанжид, Дунжаа. 2009. *Монгол бүжгийн түүхэн уламжлал, хөгжлийн шинэ хандлага*. Улаанбаатар, Монгол Улс: Соёлын дээд сургуулийн хэвлэх үйлдвэр.
3. Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга. 2012. *Цэргийн чуулгынхан*. Ред. Гансүх Ч. Улаанбаатар, Монгол Улс: Амар пресс.
4. Соёл, урлагийн их сургууль. 2018. *Соёл, урлагийн тайлбар толь, Цуврал V: Бүжиг*. Ред. Сонинтогос Э. Улаанбаатар, Монгол Улс: Мөнхийн үсэг.

Ярилцлага

1. Данзангийн Ламжавтай хийсэн ярилцлага. 2022. Улаанбаатар хот: Гэрт нь.
2. Гончигийн Тэрбиштэй хийсэн ярилцлага. 2021. Улаанбаатар хот: Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга.
3. Ламжав, Данзан. 2012. “Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын Бүжгийн албаны уран бүтээл”. Аман ярилцлага, 00:41:05